

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БӨА-2025/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баян-Өлгий аймаг  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ө.ХАРИЛБАЙ ТАНАА

2025.02.25 № 267  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд онцлох үйл явдал гараагүй байна.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

832502000272

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,542,181.00</u></b>	<b><u>13,002,559.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,542,181.00	3,834,059.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,542,181.00	3,834,059.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	9,168,500.00
36100	Барааны нөөц	-	9,168,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,658,213,992.92</u></b>	<b><u>6,725,170,127.86</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,658,213,992.92	6,725,170,127.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,616,980,253.92	6,683,613,869.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	955,181,499.93	1,099,532,270.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(246,645,643.72)	(287,790,659.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,762,492.00	208,302,492.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(90,380,040.30)	(67,193,998.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,303,566.00	98,948,116.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,469,506.27)	(42,735,940.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,238,298.00	67,927,798.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,819,131.21)	(44,724,397.82)
39209	Зам, гүүрийн байгууламж	5,854,865,886.00	5,854,865,886.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(59,916,666.51)	(256,912,196.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	196,148,000.00	196,148,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(123,565,500.00)	(143,030,499.96)
39217	Ном	277,000.00	277,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	41,233,739.00	41,556,257.87
39301	Програм хангамж	3,359,639.00	4,129,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,748,900.00)	(2,196,381.13)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,623,000.00	39,623,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,663,756,173.92</u></b>	<b><u>6,738,172,686.86</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,865,703.00</u></b>	<b><u>28,255,233.50</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,865,703.00	28,255,233.50
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,865,703.00	28,255,233.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,865,703.00	28,255,233.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,659,890,470.92</u></b>	<b><u>6,709,917,453.36</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,659,890,470.92	6,709,917,453.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	326,816,008.00	326,816,008.00
51101	Өмч: - төрийн	326,816,008.00	326,816,008.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,158,744,686.07	6,208,771,668.51
51210	Өмнөх үеийн үр дүн	6,158,744,686.07	6,158,744,686.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	50,026,982.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	174,329,776.85	174,329,776.85
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,663,756,173.92</u></b>	<b><u>6,738,172,686.86</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,389,941,262.00</b>	<b>1,359,398,809.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,839,545,125.00</b>	<b>361,565,321.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,839,545,125.00	361,565,321.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,839,545,125.00	361,565,321.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,839,545,125.00	361,565,321.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>550,396,137.00</b>	<b>997,833,488.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,149,590.00	7,725,888.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,149,590.00	7,725,888.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	546,246,547.00	990,107,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	546,246,547.00	990,107,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>645,901,402.41</b>	<b>1,309,371,826.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>645,901,402.41</b>	<b>1,309,371,826.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	631,976,492.41	1,243,186,486.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	353,406,350.57	746,658,710.00
210101	Үндсэн цалин	353,406,350.57	552,876,010.25
210102	Нэмэгдэл	-	180,991,227.75
210104	Урамшуулал	-	12,791,472.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,764,457.00	93,449,542.50
210201	Тэтгэврийн даатгал	72,293,825.00	42,646,964.50
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,284,618.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,582,498.00	10,860,741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,577,688.00	14,759,366.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,310,446.00	14,897,853.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,015,578.00	36,462,947.73
210301	Гэрэл, цахилгаан	1,415,778.00	5,621,347.73
210302	Түлш, халаалт	28,599,800.00	30,841,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,637,825.00	33,569,675.00
210401	Бичиг хэрэг	1,360,000.00	2,731,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,249,925.00	26,348,613.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,728,000.00	3,320,062.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,900.00	470,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	358,000.00	1,055,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	358,000.00	1,055,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,496,800.00	2,489,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	396,800.00	989,500.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,811,300.00	8,455,275.00
210702	Дотоод албан томилолт	4,811,300.00	8,455,275.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,827,200.00	5,213,550.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,482,700.00	2,978,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	392,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	679,100.00	981,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	44,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>123,658,981.84</b>	<b>315,831,686.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,071,600.00	15,872,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	230,000.00	921,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,203,881.84	299,038,686.06
210904	Найдваргүй авлагын алдагдал	14,153,500.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,924,910.00</b>	<b>66,185,340.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,814,500.00</b>	<b>51,794,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,100,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	50,743,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,051,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>110,410.00</b>	<b>14,390,540.27</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,410.00	14,390,540.27
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>5,744,039,859.59</u></b>	<b><u>50,026,982.44</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,050,000.00</b>	<b>-</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,050,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(4,050,000.00)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>5,739,989,859.59</u></b>	<b><u>50,026,982.44</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>550,396,137.00</u></b>	<b><u>997,833,488.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>550,396,137.00</b>	<b>997,833,488.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,149,590.00</b>	<b>7,725,888.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,149,590.00	7,725,888.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>546,246,547.00</b>	<b>990,107,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	546,246,547.00	990,107,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>545,096,137.00</u></b>	<b><u>984,235,488.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,096,137.00</b>	<b>984,235,488.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,171,227.00</b>	<b>904,611,947.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>408,377,800.00</b>	<b>719,653,476.50</b>
210101	Үндсэн цалин	292,946,418.64	360,870,549.54

210102	Нэмэгдэл	110,431,381.36	338,148,202.86
210104	Урамшуулал	5,000,000.00	20,634,724.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,047,300.00	77,073,823.50
210201	Тэтгэврийн даатгал	34,712,100.00	48,747,623.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,083,800.00	7,081,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,267,000.00	3,540,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	816,800.00	3,540,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,167,600.00	14,163,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,985,690.00	36,448,559.73
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	5,614,959.73
210302	Түлш, халаалт	28,860,690.00	30,833,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,480,490.00	32,697,163.00
210401	Бичиг хэрэг	1,631,400.00	3,002,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,092,590.00	24,171,663.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,456,600.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	299,900.00	470,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	358,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	358,000.00	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,814,000.00	2,845,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		101,700.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,336,959.00	8,455,275.00
210702	Дотоод албан томилолт	3,336,959.00	8,455,275.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,539,888.00	15,136,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,195,388.00	12,901,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	392,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	679,100.00	981,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		44,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,231,100.00	11,601,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,001,100.00	10,539,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	230,000.00	1,062,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,924,910.00</b>	<b>79,623,540.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,814,500.00	65,233,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,100,500.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		64,182,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	1,051,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	110,410.00	14,390,540.27

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,410.00	14,390,540.27
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>5,300,000.00</u></b>	<b><u>13,598,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,300,000.00</b>	<b>13,598,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,300,000.00</b>	<b>13,598,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,300,000.00	13,598,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,300,000.00	13,598,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(5,300,000.00)</u></b>	<b><u>(13,598,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	(0.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	6,157,688,003.50	6,658,833,788.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	6,157,688,003.50	6,658,833,788.35
D08	Тайлант үеийн үр дүн			50,026,982.44	50,026,982.44
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,816,008.00	174,329,776.85	6,207,714,985.94	6,708,860,770.79

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,027,397,600.00	975,717,059.73
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,027,397,600.00	975,717,059.73
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	962,164,600.00	910,484,059.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	708,153,200.00	708,208,100.00
210101	Үндсэн цалин	376,644,000.00	349,425,173.04
210102	Нэмэгдэл	311,106,200.00	338,148,202.86
210104	Урамшуулал	20,403,000.00	20,634,724.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	88,519,200.00	88,519,205.00
210201	Тэтгэврийн даатгал	60,193,000.00	60,193,001.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,081,500.00	7,081,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,540,800.00	3,540,801.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,540,800.00	3,540,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,163,100.00	14,163,101.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,773,400.00	36,448,554.73
210301	Гэрэл, цахилгаан	6,500,000.00	5,614,954.73
210302	Түлш, халаалт	60,273,400.00	30,833,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,806,500.00	31,603,200.00
210401	Бичиг хэрэг	3,002,000.00	3,002,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,281,000.00	23,095,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,353,500.00	4,336,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	470,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	700,000.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,886,600.00	2,845,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,243,400.00	1,243,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	101,700.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,100,000.00	6,606,000.00
210702	Дотоод албан томилолт	7,100,000.00	6,606,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	42,806,000.00	23,136,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,442,000.00	20,901,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	513,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	392,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	120,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	981,000.00
210807	Газрын төлбөр	128,500.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	44,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,419,700.00	12,417,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,357,700.00	11,355,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,000.00	1,062,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65,233,000.00	65,233,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	65,233,000.00	65,233,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	64,182,000.00	64,182,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	1,051,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,027,397,600.00	975,717,059.73
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,007,113,100.00	975,717,059.73
132001	Орон нутгийн төсвөөс	1,007,113,100.00	975,717,059.73
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	20,284,500.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,284,500.00	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00

<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,725,888.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,725,888.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,725,888.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,076,613.00</b>
210402	Тээвэр, шатахуун	1,076,613.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,849,275.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,849,275.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,800,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,725,888.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,725,888.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,725,888.00
131106	Төсвийн урамшуулал	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан, төрийн бодлого шийдвэр, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хөнгөн шуурхай, ил тод явуулж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад оршино” гэсэн чиг үүрэгтэйгээ нийцсэн зорилго дэвшүүлж хэрэгжүүлж ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай, тэгш хүртээмжтэй үзүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон.

Засгийн газрын 2024 оны 83 дугаар “төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай” тогтоолыг баталсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэд Санхүүгийн хяналт аудитын албан ажилладаг. Тайлант онд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/299 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.4 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Авлага		5,542.2	3,834.1	(1,708.1)
Бараа материал		-	9,168.5	9,168.5

Үндсэн хөрөнгө	6,658,214.0	6,725,170.1	66,956.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,663,756.2</b>	<b>6,738,172.7</b>	<b>74,416.5</b>
Өр төлбөр	3,865.7	28,255.2	24,389.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,659,890.5	6,709,917.5	50,027.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,663,756.2</b>	<b>6,738,172.7</b>	<b>74,416.5</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өөрчлөлт гарсан байна.

Авлагын данс 3.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 1.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ажиллагсадтай холбоотой авлага байна.

Бараа материалын данс оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 9.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь сумын шинээр ашиглалтад орох 3 дугаар цэцэрлэгийн хангамжийн материал байна.

Төсвийн хөрөнгөөр нийт 30.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 30.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 316.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 13.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 140.0 сая төгрөгийн авто машин, сумын халуун усны барилгын сайжруулалтад 85.4 сая төгрөг, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 58.9 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, сумын шинээр ашиглалтад орох 3 дугаар цэцэрлэгийн тавилга эд хогшил 5.8 сая төгрөг, аймгийн Орон нутгийн өмчийн газраас 24.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, “Си ти эс” ХХК-аас 35.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, сумын ОНХС-гаас 2.0 машин тоног төхөөрөмж авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 255 дугаар тогтоолоор 50.0 сая төгрөгийн авто машиныг аймгийн ЗДТГ-т шилжүүлсэн байна. Үндсэн хөрөнгөд нийт 299.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өглөг дансны үлдэгдэл оны эхнээс 28.2 сая төгрөгөөр өсөж 28.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь ажиллагсадтай холбоотой өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 50.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлттэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Бугат засаг даргын тамгын газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1144.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1144.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 117.2 зардлыг сая төгрөгөөр бууруулж 1027.4 сая төгрөгөөр баталсан байна.

Бугат засаг даргын тамгын газрын 2024 оны анх батлагдсан төсөв 793.8 сая төгрөг ба тодотгосон төсөв 1027.4 сая төгрөг болж анх баталснаас 233.6 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 128 дүгээр тогтоолоор тайлант оны 4 дугаар сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 1007.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 20.3 сая төгрөг бүгд 1027.4 сая төгрөгийн төсөв бүрдүүлэхээр тусгасан ба гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 990.1 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт төсвийн зарлагын 81.7 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 3.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3.2 хувийг хангамж, бараа материалын зардал, 0.7 хувийг томилолтын зардал, 2.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 1.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 6.7 хувийг бусад урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 975.7 сая төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 51.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	753,391.2	721,710.6	(31,680.6)	95.8
80102-Харуул, хамгаалалтын зардал	169,114.9	168,655.9	(459.0)	99.7
80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	65,233.0	65,233.0	-	100.0
81701-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	39,658.5	20,117.6	(19,540.9)	50.7
<b>Дүн</b>	<b>1,027,397.6</b>	<b>975,717.1</b>	<b>(51,680.5)</b>	<b>95.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий бодлого чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Тус сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэргжүүлээгүй буюу ахмадын сах байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 12.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 10.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд 25 орон тоогоор ажиллаж ирсэн ба илүү орон тоо байхгүй байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/343 дугаар захирамжаар ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зардалд 4.0 сая, Статистикийн хэлтсээс тооллого хийх зардалд 3.7 сая бүгд 7.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Бугат сумын Засаг даргын тамгын газарт 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1309.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

###### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд 171 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 165 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлж 4 мэдээллийг хугацаа хоцороож байршуулсан байна. Харин төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 95.7 хувь байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.5 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 5.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн актын төлбөрийн барагдалт болон зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	5.0	1	5.0	100%
Зөвлөмж	1	3.5		3.5	100%
Нийт дүн	1	8.5	1	8.5	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46020.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч 46020.5 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд ажиллагчидтай холбогдсон авлагыг 2,234.0 мянган төгрөгөөр, өглөгийг 681.8 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 1,552.2 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 33,893.2 мянган төгрөгөөр илүү, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 32,341.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 11,445.3 мянган төгрөгөөр дутуу, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 11,445.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан

Энэ нь Сангийн сайдын 2024 оны А/299 дүгээр тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10,039.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 5,359.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,680.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 5359.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Сумын ЗДТГ-ын зарим албан хаагч нарт олгосон 5359.5 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Бугат сумын Засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А/23 дугаар захирамжийг үндэслэн Бугат сумын санхүүгийн албаны дарга, ЗДТГ-ын нягтлан бодогч, нярав нарыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэж тус бүрийг нэг сарын үндсэн цалинтай тэнцэх бүгд 4680.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СБТ-г зөрүүтэй тайлагнасан	2	2,234.1					2	2,234.1				
ҮДТ-г зөрүүтэй тайлагнасан	2	32,341.0					2	32,341.0				
МГТ-г зөрүүтэй тайлагнасан	2	11,445.4					2	11,445.4				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>46020.5</b>					<b>6</b>	<b>46020.5</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль журам зөрчсөн	1	10039.5	1	5359.5			1	4680.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10039.5</b>	<b>1</b>	<b>5359.5</b>			<b>1</b>	<b>4680.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				
							Үүнээс				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
<b>Дүн</b>											
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
<b>Дүн</b>											
<b>Нийт дүн</b>											